

**“СПОРТЫН АВАРГА” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ОЛИМП, ДЭЛХИЙ, ТИВИЙН  
НААДАМ, УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНҮҮДЭД АМЖИЛТ ГАРГАСАН  
ТАМИРЧИН, ДАСГАЛЖУУЛАГЧ НАРТ ОЛГОХ УРАМШУУЛЛЫН ЖУРАМ**

Зорилго: Ховд аймгаас Олимп, дэлхий, тивийн наадам, улсын хэмжээнд амжилт гаргасан багш дасгалжуулагч, баг, тамирчдыг урамшуулан алдаршуулахад журмын зорилго оршино.

Олимп, Дэлхий, Тивийн наадмаас медаль хүртсэн тамирчдад дор дурдсан байдлаар мөнгөн шагнал олгоно. /төгрөгөөр/

1. Олимп, дэлхийн аваргаас медаль хүртвэл:

1/. Алтан медаль хүртсэн тамирчинд	10000000
2/. Мөнгөн медаль хүртсэн тамирчинд	8000000
3/. Хүрэл медаль хүртсэн тамирчинд	5000000

2. Тивийн наадмаас медаль хүртвэл:

1/. Алтан медаль хүртсэн тамирчинд	3000000
2/. Мөнгөн медаль хүртсэн тамирчинд	2000000
3/. Хүрэл медаль хүртсэн тамирчинд	1000000

3. Улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчдад дор дурдсан байдлаар мөнгөн шагнал олгоно./төгрөгөөр/

3.1. Насанд хүрэгчид:

1/. Алтан медаль хүртсэн тамирчинд	400.000
2/. Мөнгөн медаль хүртсэн тамирчинд	300.000
3/. Хүрэл медаль хүртсэн тамирчинд	200.000

3.2. Залуучууд:

1/. Алтан медаль хүртсэн тамирчинд	300.000
2/. Мөнгөн медаль хүртсэн тамирчинд	200.000
3/. Хүрэл медаль хүртсэн тамирчинд	100.000

3.3. Өсвөр, ахмад үе:

1/. Алтан медаль хүртсэн тамирчинд	200.000
2/. Мөнгөн медаль хүртсэн тамирчинд	150.000
3/. Хүрэл медаль хүртсэн тамирчинд	100.000

3.4. Багийн төрөлд:

1/. Улсын хэмжээнд амжилт гаргасан багийн спортын тамирчдад нас, насны төрлүүдэд дээрх зардлын 50 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг хүн тус бүрт олгоно.

2/. Амжилт гаргасан тамирчдын багш, дасгалжуулагчдад нас, насны ангилалд олгох тамирчин тус бүрт олгосон мөнгөн шагналын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг олгоно.

4.Тэмцээнд оролцсон тамирчин нь орон нутгийн спорт хамтлагаас шалгарч оролцсон байна.

5. Болзол хангасан тамирчид, дасгалжуулагчид тодорхойлолтоо аймгийн Биеийн тамир спортын газарт жил бүрийн 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ. Тодорхойлолтонд дараах материалыг хавсаргана.

1/. Тухайн тэмцээний албан ёсны урилга, журам, заавар

2/. Тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг баталсан БТС-ын асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр

3/. Тэмцээнд медальт байранд шалгарсныг нотолсон баримт диплом, гэрчилгээний хуулбар

4/. Тэмцээнд оролцсон тамирчны төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхийн хуулбар

5/.Тамирчин, дасгалжуулагчийг шагнуулахаар ирүүлсэн хүсэлт, тодорхойлолт

6. Болзол биелүүлсэн тамирчин, дасгалжуулагчийн материал нь бүрэн бүрдсэн тохиолдолд аймгийн Засаг даргын захирамжаар шийвэр гаргаж шагналыг олгоно.